БАТЛАВ:

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ОДОНЧИМЭГ

2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдөр

# СҮХБААТАР ДҮҮРЭГТ ХИЙГДЭХ ЗАМ ТАЛБАЙН УС ЗАЙЛУУЛАХ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2024 оны 09-р сарын 10-ны өдөр Дугаар 24/18 Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1 | Төсөл боловсруулах үндэслэл | - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр<br>- Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр<br>- Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 07 дугаар сарын 03-ний өдрийн Дүүргийн 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 14/88 дугаар тогтоол |
| 2 | Байршил | Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг<br>№ \| Хороо \| Байршил<br>1 \| 4-р хороо \| 149 дүгээр цэцэрлэгийн орчимд<br>2 \| 7-р хороо \| 2 дугаар сургуулийн орчимд<br>3 \| 7-р хороо \| 10 дугаар байрны зүүн талд |
| 3 | Төслийн Захиалагч | Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| 4 | Төсөл гүйцэтгэх хугацаа | Захиалагч гүйцэтгэгч талуудын байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно. |
| 5 | Төсөл боловсруулах үе шат | **1 үе шаттай**<br>- Бэлтгэл ажил (инженер геологийн дүгнэлт, дэвсгэр зургийн тодруулга)<br>- Талбайн ус зайлуулах шугамын ажлын иж бүрэн зураг төсөв |
| 6 | Төлөвлөлт, Зураг төсөл боловсруулахад ашиглах материал | Монгол Улсын хуулиуд<br>- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль<br>- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль<br>- Хот байгуулалтын тухай хууль<br>- Барилгын тухай хууль<br>- Байгаль орчныг хамгаалах тухай хууль<br>- Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль<br>- Усны тухай хууль<br>- Гамшгаас хамгаалах тухай<br>- Хот суурин газрыг дахин хөгжүүлэх хууль<br>- Бусад холбогдох хууль тогтоомжууд<br>Норм нормативууд<br>- Монгол орны нутаг дэвсгэрт тархсан олон жилийн цэвдэг хөрсөнд инженер-геологийн судалгаа хийх заавар /БД 50-102-08/ |

| | | |
|---|---|---|
| | | - Усны барилга байгууламжийн инженер, хайгуул судалгааны ажлын жишиг норм /БД 81-105-11/<br>- Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам /БНбД 33-01-03/<br>- Усны барилга байгууламжийн ачаалал ба үйлчлэл /БНбД 33-04-09/<br>- Усны барилга байгууламжийн бетон ба төмөр бетон бүтээц /БНбД 33-06-09/<br>- Усны барилга байгууламжийн хайгуул судалгааны ажлын жишиг норм /БД 81-33-10/<br>- Усны барилга байгууламжийн буурь /БНбД 33-04-09/<br>- Усны барилга байгууламжийн төсвийн суурь норм /БНбД 81-33-10/<br>- Голын гидротехникийн барилга байгууламж /БНбД 33-03-05/<br>- Хот тосгон нутаг дэвсгэр, зам талбайгаас бороо, цасны усыг зайлуулах ажлын зураг төсөл, тооцооны норм /БД 40-302-13/<br>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт /БНбД 30-01-04/<br>- Барилгад хэрэглэгдэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт /БНбД 23.01.09/<br>- Авто замын гүүр ба хоолой төсөллөх /БНбД 32-02-03/<br>- Авто зам төсөллөх ЗЗБНбД 22-004-2010<br>- Хот суурины гудамж, зам төлөвлөлт /БД 32-01-04/<br>Холбогдох журмууд<br>- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах магадлал хийх дүрэм"<br>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн инженерийн бэлтгэл арга хэмжээний усны барилга байгууламжийн төлөвлөлт, хамгаалалтын зурвас,<br>- Бусад холбогдох норм, дүрэм, стандарт, заавар |
| 7 | Ажлын зураг төслийн бүрдэл | **Талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээ:**<br>Талбайд орчны судалгаа, инженер геологи, гидрогеологи, гидрологи, инженер геодези, ус зүйн тооцоо судалгаа хийж<br>• Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хорооны 149 дүгээр цэцэрлэгийн орчмын ус зайлуулах шугамын ажлын иж бүрэн зураг төсөв<br>• Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны 2 дугаар сургуулийн орчмын ус зайлуулах шугамын ажлын иж бүрэн зураг төсөв<br>• Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны 10 дугаар байрны зүүн талд ус зайлуулах шугамын ажлын иж бүрэн зураг төсөв<br>**Баримт бичгийн иж бүрдэл:**<br>• Тайлбар бичиг |

| | | |
|---|---|---|
| | | • Инженер геологийн дүгнэлт<br>• Геологи, гидрологи, ус зүйн тооцоо судалгаа<br>• Ажлын тоо хэмжээ<br>• Материалын түүвэр<br>• Хөрөнгө оруулалтын тооцоо төсөв<br>• Дэвсгэр зураг, зай хэмжээ, өндөржилт М1:500<br>• Магадлалын нэгдсэн дүгнэлт<br>**Зураг төсөлд тавигдах шаардлага:**<br>• Зураг төслийн баримт бичиг 4 хувь. Үүнээс: график зураглал CD-ний хамт 2 хувийг захиалагчид, үндсэн хувийг архивд өгнө.<br>• Инженерийн шугам сүлжээний ажлын зургийг UTM-координатын системд хийж гүйцэтгэн батлагдсан ажлын зургийг CD-ээр хүлээлгэн өгөх<br>• Ажлын зурагт бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийг нэг дэвсгэр дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төловлөж, шугам сүлжээний ашиглалтын байгууллагуудтай зөвшилцсөн байх шаардлагатай<br>• Ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн ажлын тайлан бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 3ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/-ээр хүлээлгэж өгнө. Эскиз зургийн эх сурвалж /autocad, 3d /-ийг хүлээлгэн өгөх. Мөн Material, texture хавсаргах |
| 8 | Инженерийн хангамжийн байгууламжийн үндсэн хийц | **Замын ус зайлуулах шугам сүлжээ:**<br>- Болзошгүй үерийн аюулыг 1, 5, 10 %-ийн хангамшлын зарцуулалтыг тодорхойлж, тооцоот зарцуулыг 1%-ийн хангамшлаар тооцож борооны ус зайлуулах шугам сүлжээнд холбох<br>- Усны барилга байгууламжийн холболтын цэгийг ашиглагч "ГУББГ, ОНӨААТҮГ"-аас техникийн нөхцөл авах<br>- Байгууламжид нийлэх гуу жалга түүний оруулга, дагалдах хийц, бэхэлгээний хийцийн тооцоо хийх, хатуу урсцын хэмжээ тодорхойлох<br>- Трассын дагуу огтлолцож байгаа бусад инженерийн шугам сүлжээг хамгаалах, бэхлэх арга хэмжээг төлөвлөж, эзэмшигч байгууллагуудтай зөвшилцөх<br>- Трассанд өртөж байгаа нэгж талбаруудыг зурагт тэмдэглэж газар чөлөөлөлтийн зардал тооцох, холбогдох байгууллагуудтай зөвшилцөх<br>- Шугамын трасст орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн тохижилт, авто замын нөхөн сэргээлтийг төсөвт тусган тооцоо, судалгааг нарийвчлан гаргаж тайлбар бичигт тусгах |
| 9 | Онцгой нөхцөл | - Одоо байгаа борооны ус зайлуулах шугам сүлжээний ашиглалтын түвшинг тогтоож, талбайн өндөржилтийн зураглалыг нарийвчлан хийж, холболтын цэгийг тодорхойлж |

| | | |
|---|---|---|
| 10 | | техникийн шийдлийг гаргаж, орон зай, орчны тохижилттой уялдуулан хийх<br>- Борооны ус цугларч байгаа талбайн судалгааг гаргахдаа ус цугларч байгаа шалтгаан нөхцөлийг олж тогтоож, зураглал хийх талбайн хил хязгаарыг захиалагч талтай зөвшөлцөж гаргана<br>- Гадаргын усыг хуримтлуулах сантай болгох, дахин ашиглах боломжийн судалгаа, ногоон байгуулжамж, цэцэрлэгжүүлэлт, усалгаа, зам талбайн угаалга, машин угаалгын газарт ашиглах боломжийн судалгаа хийж ажлын зураг төсөвт тусгах<br>- Борооны ус зайлуулах шугам сүлжээний инженерийн тооцоог хамгийн боломжит хувилбарыг сонгож сүүлийн үеийн дэвшилтэт технологи ашиглан аль болох бага зардалтай байхаар төлөвлөх<br>- Борооны ус зайлуулах шугам сүлжээний ажлын зургийг даалгаврын тогтоосон байршилд гаргалгааг тооцох<br>- Гүйцэтгэгч нь Хот байгуулалт, хотын стандартын газраас зам талбайн ус зайлуулах шугам сүлжээний ажлын даалгаврыг захиалагч талтай хамтран гаргуулж зургийн ажлыг гүйцэтгэнэ |
| 10 | Архитектурын төлөвлөлтөд тавигдах шаардлага | - Талбайн ус зайлуулах шугам сүлжээг ногоон байгууламж, авто замын сүлжээтэй уялдуулан хот төлөвлөлтийн норм дүрмийн дагуу төлөвлөх<br>- Нийгмийн дэд бүтэц, хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, норм дүрмийн дагуу хүчин чадлыг нарийвчлан тогтоох |
| 11 | Зураг төсөв боловсруулах байгууллага | Усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий этгээд |
| 12 | Эдийн засгийн тооцоо төсөв | Төсвийг ESTIMATOR-PRO программаар тооцно. |
| 13 | Зураг төсвийн санхүүжилт | Дүүргийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалт |
| 14 | Зөвшилцөх байгууллага | 1. Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар<br>2. Хот байгуулалт, хотын стандартын газар<br>3. Нийслэлийн газар зохион байгуулалтын алба<br>4. Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ<br>5. Нийслэлийн замын хөгжлийн газар<br>6. Шугам сүлжээний трасст өртөж буй бусад инженерийн шугам сүлжээний хангагч байгууллагуудтай зөвшилцөх<br>7. Хот байгуулалт, хотын стандартын газар |
| 15 | Захиалагчийн хаяг, утас | Монгол улс, Улаанбаатар хот-14192, Сүхбаатар дүүргийн 7-р хороо, Денверийн гудамж, Иргэдэд үйлчлэх төв байр, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, 1002 тоот<br>Утас: +976-70070123 (1608, 1609) |

ХЯНАСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /Б.БАТ-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН /Б.САЯХҮҮ/

## СҮХБААТАР ДҮҮРЭГТ ХИЙГДЭХ УС ЗАЙЛУУЛАХ ШУГАМЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАРЫН БАЙРШИЛ

1. 4 дүгээр хороо, 149 дүгээр цэцэрлэгийн орчим




2. 7 дугаар хороо, 2 дугаар сургуулийн орчим



3. 7 дугаар хороо, 10 дугаар байрны зүүн талд

